



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/410

Хэрлэн сум

Урамшуулалд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эмнэлгийн ажилтны баяр тохиолдуулан олон жил үр бүтээлтэй ажилласан, эмнэлгийн тусламж үйлчилгээнд үнэтэй хувь нэмрээ оруулан ажиллаж байгаа эмнэлгийн ажилтнуудыг урамшуулахад 1,000,000 (нэг сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн шагнал урамшууллын зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
08 дүгээр сарын 08 ны өдрийн
08/4/40 дугаар захирамжийн хавсралт

Зардалын тооцоо

Д/д	Зардлын нэр	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Урамшуулал	100,000	10	1,000,000
Нийт				1,000,000